



ХЭНГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтийн аймаг, Хэрлэн сум, Сариг бар

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khenti@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒᠑ № ᠖᠑

танай _____

-ы № _____

-г

ХЭНГИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ДУНД
ЗАХИРАЛ Д.ДАМДИНГТҮРЭВ
ТАНАА

Танай байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг актын хамт хүргүүлж байна.

Аудитаар өгсөн актын биелэлтийг 5, 9 дүгээр сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.

Хавсралт:..... хуудас



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

232330050

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2023/112/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Чингис хот
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа
Утас: 93032714

Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2023.02.27 № 64

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгө 55,563.7 мянган төгрөг, бараа материал 125,542.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 2,271,842.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу нийт хөрөнгө 2,452,948.3 мянган төгрөг байна.

Тайлант онд улсын төсвөөс 1,244,466.6 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,188,902.9 мянган төгрөгийг зарцуулж, 55,563.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 210,127.2 сая төгрөгийн санхүүжилт авч, 209,663.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 464.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь түлш, шатах, тослох материалыг анхан шатны баримтгүй зарлагадсан, дотор ажилд зарцуулсан, цалингаас суутгах шүүхийн шийдвэрийн суутгалыг дутуу суутгасан, үндэслэлгүй цалинтай чөлөөг хавтгайруулан олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

232300092

Бусад асуудлын хэсэг

Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг 301,939.7 мянган төгрөгөөр баталсны 152,819.7 мянган төгрөг нь тогтмол зардал байна. Тодотголоор тус зардлыг 4,953.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч оны эцэст дахин 2,260.0 мянган төгрөгөөр бууруулах зохицуулалт хийж, урсгал засварын зардалд зарцуулсан байна. Энэ нь тогтмол зардлыг үндэслэлтэй төлөвлөхгүй байгаатай холбоотой. Цаашид тогтмол зардлыг оновчтой төлөвлөж, батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулах шаардлагатай.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	113,094,627.02	181,106,187.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	55,563,722.60
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	55,563,722.60
3121	Төгрөг	-	55,563,722.60
31211	Төрийн сангийн харилцах	-	55,563,722.60
35	БАРАА МАТЕРИАЛ	113,094,627.02	125,542,464.81
351	Түүхий эд материал	47,350.00	37,050.00
35130	Эм боох материал	47,350.00	37,050.00
354	Хангамжийн материал	113,047,277.02	125,505,414.81
35410	Бичиг хэргийн материал	88,430.00	2,587,220.00
35420	Аж ахуйн материал	94,816,256.38	99,502,078.93
35460	Хүнсний материал	8,217,910.00	6,448,400.00
35470	Бусад хангамжийн материал	9,924,680.64	16,967,715.88
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,312,288,093.24	2,271,842,128.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,312,288,093.24	2,271,842,128.50
392	Биет хөрөнгө	2,247,686,093.40	2,207,290,128.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,277,525,140.00	2,277,525,140.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(201,507,390.66)	(271,649,637.54)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,600,000.00	10,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,059,999.96)	(2,119,999.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	185,487,417.85	226,526,633.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(82,651,586.90)	(111,374,656.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,381,603.37	124,492,171.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,068,090.30)	(48,288,522.99)
39217	Ном	979,000.00	1,579,000.00
393	Биет бус хөрөнгө	64,601,999.84	64,552,000.00
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(200,000.16)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	64,552,000.00	64,552,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,425,382,720.26	2,452,948,315.91
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,425,382,720.26	2,452,948,315.91
51	Засгийн газрын хувь оролцоо	2,425,382,720.26	2,452,948,315.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	869,671,663.96	869,671,663.96
51101	Өмч: - төрийн	869,671,663.96	869,671,663.96
512	Хуримтлагдсан үр дүн	1,546,967,032.74	1,574,532,628.39
51210	Өмнөх үеийн үр дүн	1,596,476,595.45	1,546,967,032.74
51220	Тайлант үеийн үр дүн	(49,509,562.71)	27,565,595.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,744,023.56	8,744,023.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,425,382,720.26	2,452,948,315.91

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,196,988,779.64	1,488,803,059.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,117,279.64	28,909,259.24
120	Нийтлэг татварын бус орлого	22,117,279.64	28,909,259.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,769,922.44	28,909,259.24
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,875,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,894,922.44	28,909,259.24
120009	Бусад орлого	347,357.20	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,174,871,500.00	1,459,893,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,007,636,100.00	1,244,466,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,244,466,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,007,636,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,043,700.00	5,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,495,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,548,200.00	5,300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	140,191,700.00	210,127,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	140,191,700.00	210,127,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,237,752,819.69	1,461,237,463.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,237,752,819.69	1,461,237,463.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,192,282,733.18	1,384,044,911.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	741,418,113.00	883,474,290.00
210101	Үндсэн цалин	555,073,563.00	555,935,155.00
210102	Нэмэгдэл	140,275,864.00	270,377,365.00
210104	Урамшуулал	38,498,519.00	15,173,556.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,570,167.00	41,988,214.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,856,389.25	111,930,426.40
210201	Тэтгэврийн даатгал	67,140,778.15	76,744,742.50
210202	Тэтгэмжийн даатгал	7,459,943.23	8,686,471.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,974,958.80	7,066,392.02
210204	Ажилгүйдлийн даатгал	1,480,064.13	1,766,784.81
210205	Эрүүл мэндийн даатгал	14,800,644.94	17,666,035.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,115,501.24	155,513,000.00
210301	Гэрэл, цахилгаан	13,233,729.24	13,173,366.00
210302	Түлш, халаалт	123,081,772.00	141,859,634.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,104,765.05	3,792,300.00
210401	Бичиг хэрэг	1,684,400.00	165,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,665,370.00	480,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	221,400.00	-
210404	Ном, хэвлэл	19,002,135.05	-
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	857,200.00	366,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,674,260.00	2,780,700.00
2105	Нормативт зардал	40,803,730.00	61,532,772.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	359,200.00	-
210502	Хоол, хүнс	37,777,930.00	61,532,772.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,666,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,921,600.00	6,348,400.00
210604	Урсгал засвар	6,921,600.00	6,348,400.00
2107	Томилолт, зочны зардал	521,900.00	-
210702	Дотоод албан томилолт	521,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,152,000.00	11,447,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,555,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,891,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,388,734.64	150,006,623.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,929,500.00	19,088,947.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,763,500.00	15,721,927.45
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	102,695,734.64	115,195,748.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,470,086.51	77,192,552.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,656,304.00	76,728,536.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,256,304.00	76,728,536.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,798.76	464,016.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,798.76	464,016.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,801,983.75	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,801,983.75	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(40,764,040.05)	27,565,595.65
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,807,838.20	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,807,838.20	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,807,838.20)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(43,571,878.25)	27,565,595.65

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,186,746,500.00	1,459,893,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,875,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	11,875,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,875,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,875,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,174,871,500.00	1,459,893,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,007,636,100.00	1,244,466,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,244,466,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,007,636,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,043,700.00	5,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,495,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,548,200.00	5,300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	140,191,700.00	210,127,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	140,191,700.00	210,127,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,135,251,505.00	1,404,330,077.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,135,251,505.00	1,404,330,077.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,084,331,072.49	1,336,751,011.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	741,418,113.00	885,103,182.00
210101	Үндсэн цалин	554,754,527.00	619,589,541.00
210102	Нэмэгдэл	140,275,864.00	208,131,964.00
210104	Урамшуулал	38,504,766.00	15,393,463.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,882,956.00	41,988,214.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,856,389.25	110,301,534.40
210201	Тэтгэврийн даатгал	67,140,778.15	75,115,850.50
210202	Тэтгэмжийн даатгал	7,459,943.23	8,686,471.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,974,958.80	7,066,392.02
210204	Ажилгүйдлийн даатгал	1,480,064.13	1,766,784.81
210205	Эрүүл мэндийн даатгал	14,800,644.94	17,666,035.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,615,501.24	155,513,000.00
210301	Гэрэл, цахилгаан	13,233,729.24	13,173,366.00
210302	Түлш, халаалт	122,581,772.00	141,859,634.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,002,670.00	3,675,700.00
210401	Бичиг хэрэг	1,560,000.00	165,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,665,370.00	480,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	146,400.00	-
210404	Ном, хэвлэл	2,673,200.00	600,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	857,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,100,500.00	2,430,700.00
2105	Нормативт зардал	42,311,494.00	69,369,748.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	273,900.00	-
210502	Хоол, хүнс	40,545,494.00	69,369,748.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,492,100.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,637,400.00	7,465,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200,000.00	1,135,000.00
210604	Урсгал засвар	9,437,400.00	6,330,400.00
2107	Томиллолт, зочны зардал	491,900.00	-
210702	Дотоод албан томиллолт	491,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,152,000.00	11,522,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,555,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,966,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,845,605.00	93,800,347.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,857,500.00	79,370,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,988,105.00	14,429,997.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,920,432.51	67,579,066.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,106,650.00	67,115,050.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,706,650.00	67,115,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,798.76	464,016.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,798.76	464,016.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,801,983.75	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,801,983.75	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	51,494,995.00	55,563,722.60
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	39,619,995.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,619,995.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	39,619,995.00	-
223001	Бусад хөрөнгө	39,619,995.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(39,619,995.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11,875,000.00	55,563,722.60
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	55,563,722.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	1,596,476,595.45		2,474,892,282.97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	1,596,476,595.45	-	2,474,892,282.97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(49,509,562.71)		(49,509,562.71)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	1,546,967,032.74	-	2,425,382,720.26
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	1,546,967,032.74	-	2,425,382,720.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	1,546,967,032.74	-	2,425,382,720.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	27,565,595.65		27,565,595.65
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	1,574,532,628.39	-	2,452,948,315.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,454,593,800.00	1,398,566,061.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,454,593,800.00	1,398,566,061.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,379,995,800.00	1,331,451,011.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	924,198,700.00	885,103,182.00
210101	Үндсэн цалин	669,489,100.00	619,589,541.00
210102	Нэмэгдэл	197,972,000.00	208,131,964.00
210104	Урамшуулал	14371500.00	15393463.00
210105	Гэрээт ажлын хөлс	42366100.00	41988214.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,516,000.00	110,301,534.40
210201	Тэтгэврийн даатгал	78,522,600.00	75,115,850.50
210202	Тэтгэмжийн даатгал	9,248,400.00	8,686,471.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,398,700.00	7,066,392.02
210204	Ажилгүйдлийн даатгал	1,849,700.00	1,766,784.81
210205	Эрүүл мэндийн даатгал	18,496,600.00	17,666,035.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	155,513,000.00	155,513,000.00
210301	Гэрэл, цахилгаан	13,653,300.00	13,173,366.00
210302	Түлш, халаалт	141,859,700.00	141,859,634.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	480000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	630,800.00	630,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	630,800.00	630,700.00
2105	Нормативт зардал	72,573,700.00	69,229,748.00
210502	Хоол, хүнс	72,573,700.00	69,229,748.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,330,400.00	6,330,400.00
210604	Урсгал засвар	6,330,400.00	6,330,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,522,100.00	11,522,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,555,400.00	2,555,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,966,700.00	8,966,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,711,100.00	92,820,347.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,261,100.00	79,370,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,450,000.00	13,449,997.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,598,000.00	67,115,050.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,598,000.00	67,115,050.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	74,598,000.00	67,115,050.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,454,593,800.00	1,454,129,784.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,244,466,600.00	1,244,466,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,244,466,600.00	1,244,466,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	210,127,200.00	209,663,184.00
132001	Орон нутгийн төсвөөс	210,127,200.00	209,663,184.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		55,563,722.60

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,300,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,300,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,045,000.00
210401	Бичиг хэрэг	165,000.00
210402	Тээвэр, шатахуун	480,000.00
210404	Ном, хэвлэл	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00
2105	Нормативт зардал	140,000.00
210502	Хоол, хүнс	140,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,135,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,135,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	980,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	980,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,300,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,300,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага юм.

Тогтвортой хөгжлийн бодлогыг орон нутагт манлайлан хэрэгжүүлэх, төрийн болон салбарын бодлогыг үйл ажиллагаандаа уялдуулан байгууллагын хөгжлийг дэмжих, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын сэтгэл зүйн болон материаллаг таатай орчныг бүрдүүлэх, эерэг хандлага бүхий ирээдүйн иргэн төлөвшүүлэх, удирдлагын арга барилыг хууль зүй болон нийгмийн шаардлагад нийцүүлэх зорилго тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Дадал сумын Ерөнхий боловсролын сургууль нь Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг суурь зардал болон дундаж нормативт үндэслэсэн хувьсах зардал, сургалтын байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үнэлгээний үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлаар санхүүжүүлж болно.” гэсэн өөрчлөлт орсноор, Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол гарч нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар тооцсон зардлаар санхүүжсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Боловсролын салбарын хэмжээнд дагаж мөрдөхөөр боловсруулан баталж мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27.565.6 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	55,563.7	55,563.7
Бараа материал	113,094.6	125,542.5	12,447.8
Үндсэн хөрөнгө	2,312,288.1	2,271,842.1	(40,446.0)
Нийт хөрөнгө	2,425,382.7	2,452,948.3	27,565.6
Засгийн газрын оролцоо	2,425,382.7	2,452,948.3	27,565.6
Өмнөх үеийн үр дүн	1,596,476.6	1,546,967.0	(49,509.6)
Тайлант үеийн үр дүн	(49,509.6)	27,565.6	77,075.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,744.0	8,744.0	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,425,382.7	2,452,948.3	27,565.6

Дээрх хүснэгтээс харахад өсөлтийн дийлэнх хувийг мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл эзэлж байгаа бөгөөд энэ нь улсын төсвийн урсгал санхүүжилтийн дансны үлдэгдэл байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг улсын төсвөөс 843,086.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 301,713.1 мянган төгрөг нийт зарлагыг 1,144,800.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 258,049.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,402,849.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 51,744.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,244,466.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 210,127.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,244,466.6 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 210,127.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,393,566.1 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 байр ашиглалтын үйлчилгээ	3,586.7	3,584.3	2.4	99.9%
2	80312 сургалт семинар	1,793.3	905.0	888.3	50.5%
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	4,124.7	4,124.7	-	100.0%
4	81801 үдийн цай хөтөлбөр	74,598.0	67,115.1	7,482.9	90.0%
5	81806 дотуур байрны үйлчилгээ	121,144.2	116,547.1	4,597.1	96.2%
6	81816 хүүхдэд ээлтэй сургалтын орчин	46,455.0	46,455.0	-	100.0%
7	81823 боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	8,070.0	8,070.0	-	100.0%
8	81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	887,062.4	844,687.1	42,375.3	95.2%
9	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	87,003.8	86,786.1	217.7	99.7%
10	81848 Сурах бичгийн түрээс	2,555.4	2,555.4	-	100.0%
11	83603 Нэмэлт - Олон улсын байгууллагаас олгосон	5,000.0	5,000.0	-	100%
12	83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	3,073.1	3,073.1	-	100.0%
13	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	161,843.4	161,843.4	-	100.0%
14	80112 Нийтлэг үйлчилгээ	48,283.8	47,819.8	464.0	99.0%
	Дүн	1,454,593.8	1,393,566.1	61,027.7	95.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Байгаль орчны мэдээлэл сургалтын төвөөс 5,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, олон улсын байгууллагын дэмжлэг 300.0 мянган төгрөг нийт 5,300.0 мянган төгрөгийн санхүүжилтийг сургалтын материал бэлтгэхэд бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 1,237,752.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,237.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалинг 42,375.2 мянган төгрөгөөр, дотуур байрны үйлчилгээг 4,597.1 мянган төгрөгөөр хэмнэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сайн байлаа.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт /мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	7,500.0	1	7,500.0	100%
Албан шаардлага	2	292,960.6	2	292,960.6	100%
Нийт дүн	3	300,460.6	3	300,460.6	100%

Өмнөх оны аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын зарцуулалт, ажилтнуудын цагийн бүртгэл, цалингийн тооцооллыг авч үзэх болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй байна.

Аудитаар нийт 6,019.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 4 төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт

Цалингийн зардлын тулгалтаар байгууллагын дотоод журамд ажилтанд төрсөн өдөр тэмдэглэх, хувийн ажлаар хот, хөдөө явахад жилд 5 хоногийн цалинтай чөлөө олгох гэж хууль тогтоомжид нийцээгүй заалтыг оруулж, цалинтай чөлөөг 5 хоногоос дээш хугацаанд өгч нийт 2,702.2 мянган төгрөгийн цалин олгосон.

Цалингаас суутгах шүүхийн шийдвэрийн суутгалыг 621.7 мянган төгрөгөөр дутуу суутган төлсөн.

Шатах, тослох материалын зарцуулалтыг анхан шатны баримттай тулгахад 1,063.4 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүй, жолоочийн тооцооны хуудсаар тулгахад 1,632.2 мянган төгрөгийн шатахууныг дотор ажилд зарцуулсан байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
байхгүй												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн суутгал дутуу хийсэн	1	621.7	1	621.7								
Анхан шатны баримтгүй материал зарлагдсан	1	1,063.4	1	1,063.4								
Шатахууныг дотор ажилд зарцуулсан	1	1,632.2	1	1,632.2								
Үндэслэлгүй цалин хөлс олгосон	1	2,702.2	1	2,702.2								
Дүн	4	6,019.5	4	6,019.5								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн								



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 23/АДБТ0448
ХДА-2023/112/НА-СТА-ТНЗ

Чингис хот

Г

Төлбөр барагдуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын дотоод журамд ажилтанд төрсөн өдөр тэмдэглэх, хувийн ажлаар хот, хөдөө явахад жилд 5 хоногийн цалинтай чөлөө олгох тухай хууль тогтоомжид нийцээгүй заалтыг оруулан цалинтай чөлөөг 5 хоногоос дээш хугацаанд өгч нийт 2,702.2 сая төгрөгийн цалин олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д "Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ." гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ажиллаагүй хугацаанд олгосон 2,702.2 мянган төгрөгийн цалинг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн захирал Д.Дамдинпүрэв, нягтлан бодогч Э.Дэнсмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

Д.ОЮУНТУЯА

Б.АРИУНАА

2317144297
СЮА0046 9074082



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 24/А2370448

Чингис хот

ХЭА-2023/112/НА-СТА-ТЦЗ

Г

Төлбөр барагдуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын тайлангийн тулгалтаар 1,603.4 мянган төгрөгийн түлш, шатах, тослох материалыг анхан шатны баримтгүй зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь::

1. Анхан шатны баримтгүй зарцуулсан түлш, шатах тослох материалын 1,063.4 мянган төгрөгийг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн захирал Д.Дамдинпүрэв, нягтлан бодогч Э.Дэнсмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

АУДИТОР

Б.АРИУНАА

2317144297
СЮА0046 9074082



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 25/A2370448
ХАА-2023/112/НА-СТА-ТЦЗ

Чингис хот

Г Төлбөр барагдуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын тайлангийн тулгалтаар байгууллагын бүртгэлтэй суудлын автомашиныг дотор ажилд унаж нийт 1,632.2 мянган төгрөгийн түлш, шатах, тослох материал зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.", 6.3-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно." гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дотор ажилд, суудлын автомашин ашиглах эрхгүй албан тушаалтны зарцуулсан 1,632.2 мянган төгрөгийг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн захирал Д.Дамдинпүрэв, нягтлан бодогч Э.Дэнсмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

Д.ОЮУНТУЯА

Б.АРИУНАА

2317144297



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 26/АДЗТ0448
ХТД-2023/112/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Цалингаас суутгах 621.7 мянган төгрөгийн шүүхийн шийдвэрийн суутгалыг суутгалгүй илүү шилжүүлэн авлага үүсгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасныг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь::

1. Цалингаас суутгаагүй, байгууллагаас төлөгдсөн 621.7 мянган төгрөгийг Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дадал сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн захирал Д.Дамдинпүрэв, нягтлан бодогч Э.Дэнсмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



Д.ОЮУНТУЯА

Б.АРИУНАА